



**МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар A/381

Номгон


Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн
байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 10.9.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 342, аймгийн Засаг даргын 2021 оны A/342 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 50 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвартын батлагдсан тохиолдлууд өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан иргэд, олон нийтийнхээ эрүүл, аюулгүй байдлыг хангах зорилгоор коронавируст халдвартын батлагдсан тохиолдлууд илэрсэн сумдуудад 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 08:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 24:00 цаг хүртэл хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлж, холбогдох хорио цээр, хязгаарлалтын арга хэмжээ авахыг сумдын Засаг дарга наарт зөвшөөрсүгэй.

2. Дээрх хугацаанд батлагдсан тохиолдлуудын ойрын болон дам хавьтлуудыг тогтоон халдвартын голомтыг богино хугацаанд тогтоож, ариутгал халдвартгүйжүүлэлтийг нэгдсэн журмаар зохион байгуулж, халдварт хамгааллын дэглэм сахиулах, сээрэмжлүүлэг мэдээлэл хүргэх зэрэг халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Ж.Алтангэрэл)-т даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

621010961